



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/10

Шивээговь сум

Отроор мал оруулахыг хориглох
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3.г, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 59 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2011 оны 26 дугаар тогтоол “Бэлчээр ашиглах журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шивээговь сумын бэлчээрийн даац 37,5%-иар хэтэрч өөрийн сумын малд бэлчээр хүрэлцэхгүй, бэлчээрт орсон цасны зузаан нэмэгдэж, өвөлжилт хүндэрч, зудын эрсдэлийн нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа тул 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаагаар гадны аймаг, сумаас отрын мал оруулахыг хориглосугай.

2. Захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Нандинцэцэг/, 2 дугаар багийн Засаг дарга /С.Отгонбаатар/, Байгаль хамгаалагч /О.Отгонбаяр/, Хөдөө аж ахуйн тасгийн Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Баярцэцэг/, Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хошууч /Ц.Баасанжав/ нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212:0026